

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Төрийн аудитын санал, дүгнэлт.....	2
Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
Менежментийн захидал.....	17
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/589
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Цахим эрүүл мэнд” төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Цахим эрүүл мэнд” төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн, үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу, үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,955,153,295.94	2,145,681,258.67
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,953,656,203.94	1,612,785,770.86
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,953,656,203.94	1,612,785,770.86
31210	Төгрөг	1,953,656,203.94	1,612,785,770.86
31211	Төрийн сангийн харилцах	562,723,604.57	803,489,112.52
31213	Арилжааны банк дахь харилцах	1,390,932,599.37	809,296,658.34
33	АВЛАГА	1,497,092.00	2,374,267.90
33500	Бусад авлага	1,497,092.00	2,374,267.90
33510	Байгууллагаас авах авлага	1,497,092.00	2,374,267.90
34	УРЬДЧИЛГАА	0.00	530,521,219.91
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	530,521,219.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	158,216,834.42	136,119,112.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	158,216,834.42	136,119,112.59
39200	Биет хөрөнгө	155,608,834.42	134,815,112.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,727,272.73	132,727,272.73
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,545,454.55)	(39,818,181.82)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	47,549,485.48	53,917,801.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,644,312.53)	(33,412,242.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,791,754.33	33,791,754.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,269,911.04)	(12,391,291.02)
39300	Биет бус хөрөнгө	2,608,000.00	1,304,000.00
39301	Програм хангамж	6,520,000.00	6,520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,912,000.00)	(5,216,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,113,370,130.36	2,281,800,371.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	272,323.79	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	272,323.79	0.00
41300	Өглөг	272,323.79	0.00
41360	Бусад өглөг	272,323.79	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	272,323.79	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,113,097,806.57	2,281,800,371.23
51	Засгийн газрын хувь оролцоо	2,113,097,806.57	2,281,800,371.23
51200	Хуримтлагдсан үр дүн	2,113,097,806.57	2,281,800,371.23
51210	Өмнөх үеийн үр дүн	2,263,613,315.40	2,113,370,130.36
51220	Тайлант үеийн үр дүн	(150,515,508.83)	168,430,240.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,113,370,130.36	2,281,800,371.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,281,078,517.07	7,312,126,553.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,241,778,517.07	7,267,126,553.64
120	Нийтлэг татварын бус орлого	2,241,778,517.07	7,267,126,553.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,159,006,549.82	7,267,126,553.64
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,318,607.92	19,269,145.93
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,115,687,941.90	7,247,857,407.71
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	82,771,967.25	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,300,000.00	45,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	39,300,000.00	45,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	39,300,000.00	45,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,472,323,032.51	1,293,328,943.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,472,323,032.51	1,293,328,943.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,433,023,032.51	1,259,787,580.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	243,038,101.52
210101	Үндсэн цалин	0.00	243,038,101.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	32,211,935.30
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	32,211,935.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,700,000.00	3,700,000.00
210304	Байрны түрээс	3,700,000.00	3,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,153,004.62	40,518,211.85
210401	Бичиг хэрэг	5,392,267.14	6,122,673.18
210402	Тээвэр, шатахуун	8,180,008.00	6,607,088.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,373,370.48	16,244,131.55
210404	Ном, хэвлэл	6,460,372.00	4,758,636.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,746,987.00	6,785,681.83
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,153,295.42	590,000.00
210604	Урсгал засвар	4,153,295.42	590,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,326,645.00	25,304,590.58
210701	Гадаад албан томилолт	0.00	4,007,350.00
210702	Дотоод албан томилолт	4,326,645.00	21,297,240.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,359,735,290.62	883,583,599.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,276,963,323.37	862,080,530.99
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	82,771,967.25	21,503,068.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,954,796.85	30,841,141.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,375,103.74
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,954,796.85	28,466,037.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,300,000.00	33,541,363.63
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,300,000.00	33,541,363.63

213302	Хаагдсан данс	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,300,000.00	33,541,363.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(191,244,515.44)	6,018,797,609.87
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	40,729,006.61	84,070,087.78
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	40,729,006.61	84,070,087.78
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	5,934,437,456.78
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	3,819,274.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	0.00	5,930,618,182.78
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(150,515,508.83)	168,430,240.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,285,820,711.77	7,312,126,553.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,246,520,711.77	7,267,126,553.65
120	Нийтлэг татварын бус орлого	4,246,520,711.77	7,267,126,553.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,240,395,033.47	7,267,126,553.65
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,192,929.62	19,269,145.94
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	10,557,560.95	0.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,115,687,941.90	7,247,857,407.71
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	2,076,956,601.00	0.00
120009	Бусад орлого	6,125,678.30	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,300,000.00	45,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	39,300,000.00	45,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	39,300,000.00	45,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,372,893,514.44	1,802,629,617.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,372,893,514.44	1,802,629,617.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,296,400,584.82	1,769,088,254.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	243,146,032.53
210101	Үндсэн цалин	0.00	243,146,032.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	32,211,935.30
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	32,211,935.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,700,000.00	3,700,000.00
210304	Байрны түрээс	3,700,000.00	3,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,685,939.62	40,445,384.37
210401	Бичиг хэрэг	5,392,267.14	6,622,673.18
210402	Тээвэр, шатахуун	8,712,943.00	6,034,261.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,373,370.48	16,244,131.55
210404	Ном, хэвлэл	6,460,372.00	4,758,636.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,746,987.00	6,785,681.83
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,599,416.99	6,958,316.27
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,959,121.49	6,368,316.27
210602	Тавилга	2,487,000.08	0.00
210604	Урсгал засвар	4,153,295.42	590,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,326,645.00	25,304,590.58
210701	Гадаад албан томилолт	0.00	4,007,350.00
210702	Дотоод албан томилолт	4,326,645.00	21,297,240.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,239,088,583.21	1,414,104,819.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,239,088,583.21	1,387,101,750.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	5,500,000.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	21,503,068.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,217,175.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,217,175.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,492,929.62	33,541,363.63
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,492,929.62	33,541,363.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,300,000.00	33,541,363.63
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	37,192,929.62	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,912,927,197.33	5,509,496,935.95
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	5,930,618,182.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	5,930,618,182.81
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	5,930,618,182.81
222001	Тоног төхөөрөмж	0.00	5,930,618,182.81
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	(5,930,618,182.81)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	40,729,006.61	80,250,813.78
14	Бусад эх үүсвэр	40,729,006.61	84,070,087.78
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	40,729,006.61	84,070,087.78
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	3,819,274.00
250006	Бусад зардал	0.00	3,819,274.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,953,656,203.94	(340,870,433.08)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,953,656,203.94
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,953,656,203.94	1,612,785,770.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,263,613,315.40	2,263,613,315.40
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,263,613,315.40	2,263,613,315.40
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(150,515,508.83)	(150,515,508.83)
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	2,113,097,806.57	2,113,097,806.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,113,097,806.57	2,113,097,806.57
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	272,323.79	272,323.79
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	168,430,240.87	168,430,240.87
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	2,281,800,371.23	2,281,800,371.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,973,856,000.00	7,699,706,436.88	274,149,563.12	96.5
УРСГАЛ ЗАРДАЛ	2,043,236,000.00	1,769,088,254.07	274,147,745.93	86.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,043,236,000.00	1,769,088,254.07	274,147,745.93	86.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,000,000.00	243,146,032.53	96,853,967.47	71.5
Үндсэн цалин	340,000,000.00	243,146,032.53	96,853,967.47	71.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,000,000.00	32,211,935.30	7,788,064.70	80.5
Эрүүл мэндийн даатгал	40,000,000.00	32,211,935.30	7,788,064.70	80.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,700,000.00	3,700,000.00	0.00	100
Байрны түрээс	3,700,000.00	3,700,000.00	0.00	100
Хангамж, бараа материалын зардал	43,920,000.00	40,445,384.37	3,474,615.63	92.0
Бичиг хэрэг	6,874,000.00	6,622,673.18	251,326.82	96.3
Тээвэр, шатахуун	6,798,000.00	6,034,261.45	763,738.55	88.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,703,000.00	16,244,131.55	2,458,868.45	86.8
Ном, хэвлэл	4,759,000.00	4,758,636.36	363.64	99.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,786,000.00	6,785,681.83	318.17	100
Эд хогшил, урсгал засварын зардал	6,959,000.00	6,958,316.27	683.73	99.9
Багаж, техник, хэрэгсэл	6,369,000.00	6,368,316.27	683.73	99.9
Урсгал засвар	590,000.00	590,000.00	0.00	100
Томилолт, зочны зардал	28,477,000.00	25,304,590.58	3,172,409.42	88.8
Гадаад албан томилолт	0.00	4,007,350.00	(4,007,350.00)	-
Дотоод албан томилолт	28,477,000.00	21,297,240.58	7,179,759.42	74.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,576,963,000.00	1,414,104,819.57	162,858,180.43	89.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,571,463,000.00	1,387,101,750.87	184,361,249.13	88.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	5,500,000.00	0.00	100
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	21,503,068.70	(21,503,068.70)	-
Бараа үйлчилгээний бусад зардал	3,217,000.00	3,217,175.45	(175.45)	100
Бараа үйлчилгээний бусад зардал	3,217,000.00	3,217,175.45	(175.45)	100
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,930,620,000.00	5,930,618,182.81	1,817.19	100
Тоног төхөөрөмж	5,930,620,000.00	5,930,618,182.81	1,817.19	100
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,973,856,000.00	7,312,126,553.65	661,729,446.35	91.7

УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,000,000.00	45,000,000.00	0.00	100
Улсын төсвөөс санхүүжих	45,000,000.00	45,000,000.00	0.00	100
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,928,856,000.00	7,267,126,553.65	661,729,446.35	91.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	19,269,145.94	(19,269,145.94)	-
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,928,856,000.00	7,247,857,407.71	680,998,592.29	91.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,953,656,203.94	(1,953,656,203.94)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,612,785,770.86	(1,612,785,770.86)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	8	6	2	75.0
Удирдах ажилтан	1	1	0	100
Гүйцэтгэх ажилтан	7	5	2	71.4
Үйлчлэх ажилтан	0	0	0	-
Гэрээт ажилтан	0	0	0	-

Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Цахим эрүүл мэнд” төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн зохицуулагч С.Энхболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх, үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн программыг сайжруулах талаарх зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Интер Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, ахлах аудитор С.Уртнасан, аудитор Б.Гомбо, чанарын хяналтын менежер П.Дарамрагчаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Цахим эрүүл мэнд” төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2021 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 03 тоот албан бичгээр Интер Аудит ХХК-д хүргүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Цахим эрүүл мэнд” төслийн санхүүжилтийн хэлэлцээрийг 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа нь 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдөр албан ёсоор эхэлсэн байна. Энэхүү төсөл нь 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хэрэгжих бөгөөд төслийн хугацаанд нийт 19.5 сая ам.долларын санхүүжилтийг төлөвлөсөн байна.

Төслийн хүрээнд хийх ажил: “Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ” болон “Дүрс архивлан хадгалах, солилцох систем”-ийг хөгжүүлж нэвтрүүлэх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, Үндэсний дата төвийг эрүүл мэндийн мэдээлэл хадгалах тоног төхөөрөмжөөр хангаж суурилуулах.

Дээрх зорилтын хүрээнд дараах бүрэлдэхүүн хэсгүүдэд байна. Үүнд:

1. Цахим эрүүл мэндийн нэгдсэн тогтолцоо байгуулах: (15.9 сая ам доллар)
 - 1.1. Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ болон холбогдох цахим үйлчилгээг хөгжүүлэх,
 - 1.2. Эрүүл мэндийн өгөгдлийн стандартчилах,
 - 1.3 Мэдээллийн технологийн дэд бүтэц байгуулах.
2. Байгууллагын чадавхыг бэхжүүлэх: (2.3 сая ам доллар)
 - 2.1. Компьютерын ур чадвар болон эрүүл мэндийн мэдээллийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх,
 - 2.2. Интернэтийн холболт хийх замаар цахим эрүүл мэндийн системийн суурийг байгуулах.

3. Төслийн удирдлагын чиг үүргийг гүйцэтгэх: (1.3 сая ам доллар)

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 114 дүгээр тогтоол “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай”.
- “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Цахим эрүүл мэнд” төслийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд санхүүгийн тайлангаа гаргахдаа 2007 онд Сангийн сайдын 326 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, УСНББОУС, Дэлхийн Банкны Санхүүгийн гарын авлагыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

Тайлант хугацаанд дээд шатны эрх байгууллагуудаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,227,766.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 144,555.3 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Цахим эрүүл мэнд” төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 168,430.2 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,953,656.2	1,612,785.8	(340,870.4)
Авлага	1,497.1	2,374.3	877.2
Урьдчилгаа	0.0	530,521.2	530,521.2
Үндсэн хөрөнгө	158,216.8	136,119.1	(22,097.7)
Нийт хөрөнгө	2,113,370.1	2,281,800.4	168,430.2
Өр төлбөр	272.3	0.0	(272.3)

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,113,097.8	2,281,800.4	168,702.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,113,370.1	2,281,800.4	168,430.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,612,785.8 мянган төгрөг болж 340,870.4 мянган төгрөгөөр буурсан нь Дэлхийн Банк 200.0 мянган ам.доллороос давсан гэрээний төлбөрийг гүйцэтгэгч компаниуд руу шууд шилжүүлж, бага дүнтэй цөөн тооны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын санхүүжилтийг ТХН-ийн данс руу хийснээс шалтгаалжээ.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 530,521.2 мянган төгрөг болж өссөн нь Дүрс архивлах хадгалах солилцох Олон улсын гэрээт ажлын санхүүжилтийн 10 хувийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 136,119.1 мянган төгрөг болж 22,097.7 мянган төгрөгөөр буурсан нь авто тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмж, компьютерын элэгдлийн зардал өссөнөөс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 6,368.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,281,800.4 мянган төгрөг болж 168,702.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Дэлхийн Банкнаас зээлийн санхүүжилтээр авсан мөнгөө төлөвлөгөөний дагуу бүрэн зарцуулж чадаагүй, төсөвлөгдсөн зарим зардлууд гараагүйн улмаас шалтгаалжээ. Энэ нь дараагийн тайлант онд зардал их гарч, засгийн газрын хувь оролцоо буурах нөлөөтэй байна.

“Цахим эрүүл мэнд” төслийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 5,031,048.0 мянган төгрөгөөр буюу 221 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Гадаад эх үүсвэрээс санхүүжих орлого байна. Энэ нь ТХН тайлант онд шууд төлбөрийн горимоор буюу Дэлхийн банкны зүгээс ТХН-ийн дансаар дамжуулалгүйгээр, гүйцэтгэгчийн данс руу шилжүүлсэн төлбөр өмнөх онтой харьцуулбал өндөр байсны улмаас үүссэн байна.

Нийт зардал өмнөх оноос 4,751,624.1 мянган төгрөгөөр буюу 192 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилтийн зардлууд байна. Энэ нь Дэлхийн банкны зүгээс ТХН-ийн дансаар дамжуулалгүйгээр, гүйцэтгэгчийн данс руу төлбөр шилжүүлсний улмаас өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,973,856.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,973,856.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 45,000.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 7,928,856.0 мянган төгрөгийг гадаадын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 45,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, гадаадын эх үүсвэрээс 7,247,857.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 19,269.1 мянган төгрөг, нийт 7,312,126.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,769,088.2 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 5,930,618.2 мянган төгрөг зарцуулж 33,541.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,966,706.4 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төлөвлөсөн 8 худалдан авах ажиллагаа хийгдээгүй боловч Ковид-19 цар тахлын улмаас Эрүүл мэндийн яамны хүсэлтээр “Цахим эрүүл мэнд” төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан 2.2 сая ам.долларын зөөврийн болон суурин эхо аппарат, амьсгалын аппарат худалдаж авсны төлбөрийг гүйцэтгэгч тал руу шилжүүлсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээний төсөвт зардлыг гаргаагүйтэй холбоотой байна.

Тус төслийн хүрээнд тайлант хугацаанд нийт 11 худалдан авалт төлөвлөгдсөнөөс 5 худалдан авалт олон улсын нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 3 харьцуулалтын аргаар, 1 шууд гэрээ байгуулах аргаар, 1 дотоодын нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаар төлөвлөсөн. Эдгээрээс 3 гэрээт ажил хэрэгжилтийн шатандаа байна. Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ боловсруулах ажлын гэрээ байгуулагдсан боловч Сангийн яамны зүгээс эрүүл мэндийн салбарт хийгдэж байгаа өөр ажилтай давхацсан гэдэг шалтгаанаар түр хойшлуулсан байна. Үүний улмаас Дэлхийн банкны 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 135/20 тоот албан тоотоор эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ боловсруулах ажилтай холбоотой Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан 7 ажлыг түр зогсоосон.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 102 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл, хугацаа хоцроосон 20 мэдээлэл, 36 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, 1 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдэхээр нөхцөл байдал үүсээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

“Цахим эрүүл мэнд” төслийн 2020 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах 159 мэдээллээс 20 мэдээллийг хугацаа хоцроож, 36 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ боловсруулах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх гэрээ 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдөр байгуулж, гүйцэтгэгч эхлэлтийн тайлангаа боловсруулж эхэлсэн. “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлт 2021 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан уг ажил нь давхардал үүсгэж байгаа гэдэг шалтгаанаар Сангийн яамнаас санхүүжилтийг түр зогсоосон. Энэхүү ажилтай холбоотойгоор эрх бүхий байгууллагын гаргасан хууль тогтоомж, дүрэмж, журам, шийдвэрүүдийг дараагийн аудитаар нарийвчлан судалж, үргэлжлүүлэн хийгдэх эсэхийг анхаарч үзэх.

Мөн өмнөх аудитын өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

ТХН-ийн ашигладаг санхүүгийн программ нь Сангийн Яамны зүгээс хүлээн зөвшөөрөгдөөгүй, ерөнхий журнал болон бусад шаардлагатай мэдээллийг гаргах боломжгүй. Мөн Сангийн сайдын 2007 оны 196 тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягтаар тайлан нь гарддаггүй.

1.2. Эрсдэл:

Үйл ажиллагааны онцлогтоо тохируулан санхүүгийн тайлан, бүртгэл, тооцоогоо хөтөлж чадахгүй байх, санхүүгийн программаас гарч буй мэдээлэл шаардлага хангахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн программыг сайжруулах, эсвэл Сангийн Яамны зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн, УСНББОУС болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудад нийцсэн санхүүгийн программыг сонгож хэрэглэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

2. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төслийн үйл ажиллагааны 1 чиглэлийг зогсоосны улмаас нийт 8 ажил хойшлогдоод байгаа нь тасралтгүй байх зарчимд эрсдэл үүссэн болохыг илрүүлсэн.

2.2. Эрсдэл:

Төсөл нь цаашид үргэлжлэх эсэхэд эргэлзээтэй байдал үүсгэж байна.

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйл.Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах: 41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/92/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр: Цахим эрүүл мэнд	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны сайтад нийт 158 мэдээллийг оруулахаас 20 мэдээллийг хугацаа хоцроож, 36 мэдээллийг орхигдуулсан, зарим мэдээллийг алдаатай оруулсан болохыг тогтоосон	-	Албан шаардлага	Санхүүгийн ажилтан	П.Сувд
2	ТХН-ийн ашигладаг санхүүгийн программ нь Сангийн Яамны зүгээс хүлээн зөвшөөрөгдөөгүй, ерөнхий журнал зэрэг шаардлагатай мэдээллийг гаргах боломжгүй. Мөн Сангийн сайдын 2007 оны 196 тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягтаар тайлан нь гарддаггүй	-	Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	П.Сувд
3	Төслийн үйл ажиллагааны 1 чиглэлийг зогсоосны улмаас нийт 8 ажил хойшлогдоод байгаа нь тасралтгүй байх зарчимд эрсдэл үүссэн болохыг илрүүлсэн	-	Зөвлөмж	Төслийн зохицуулагч	С.Энхболд
	Нийт дүн	-			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 220/А0170079
САГ-2021/92/СТА-7ХМ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Цахим эрүүл мэнд" төслийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Цахим эрүүл мэнд" төслийн 2020 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах 159 мэдээллээс 20 мэдээллийг хугацаа хоцроож, 36 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг үнэн зөв, ил тод, хугацаанд нь байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллахыг "Цахим эрүүл мэнд" төслийн санхүүгийн ажилтан П.Сувдад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

ИНТЕР АУДИТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

Ч.МӨНХБАЯР